

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗААВАРЧИЛГАА

Далайн захиргааны мэргэжилтэн, усан замын тээврийн хяналтын улсын байцаагчид нь усан замын тээврийн хяналт, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх үедээ дараах зааварчилгааг мөрдлөг болгон ажиллана.

- Хяналт, шалгалт хийх үедээ дүрэмт хувцас, улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг, хяналт, шалгалтын удирдамж, хяналтын хуудас зэргийг биедээ авч, ажилд гарахын өмнө зохих бэлтгэлийг зайлшгүй хангасан байна.
- Үзлэгийн талбайг сонгохдоо бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулахгүй, харагдахуйц ил газар зохих тэмдэг, тэмдэглэгээтэй, тогтсон усгүй хатуу хөрстэй тэгш газар байна.
- Усан замын тээврийн хэрэгслийн кабин, чиргүүл дээр гарахдаа анхаарал болгоомжтой ажиллана.
- Агуулах, байранд байрлуулсан усан замын тээврийн хэрэгсэлд үзлэг хийхээс өмнө тухайн байранд агааржуулалтыг сайн хийсэн байна.
- Дунд болон том оврын усан замын тээврийн хэрэгсэлд үзлэг хийхдээ урьдчилан аюулгүй ажиллагааны зааварчилгааг авч, зориулалтын хамгаалах хувцас, хэрэгсэлтэй байна.
- Шатахууны сав, түүний ойр орчимд тамхи татах, ил гал гаргахыг хориглоно.
- Шатамхай бодис, шатахууны савны тагийг нээхдээ цохилтонд өртөж, гэмтэхээс сэргийлэх сэрэмж болгоомжтой ажиллана.
- Хэрэв хяналт, шалгалтын явцад хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдаагүй зөрчил илэрсэн тохиолдолд тухайн тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч зөрчлийг арилгах хүртэл хяналт шалгалтыг тэр даруй зогсооно.
- Усан замын тээврийн хэрэгслийн тавцангийн хаалт, хашлагын ирмэгийг налж зогсох, дээр нь суухыг хориглоно.
- Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийхэд тавцангийн шатны бариул, хаалт хашлага эвдрэл гэмтэлтэй байгаа эсэхийг шалгаж, халтирч унахаас болгоомжилно.
- Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх үед тухайн тээврийн хэрэгсэл дээр ямар нэгэн зорчигч байлгахыг хориглоно.
- Усан замын тээврийн хэрэгслийн лүкний түгжээг онгойлгох, буулгахдаа цохиулж, дээрээсээ унагаж даруулахаас сэрэмжилнэ. Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгүүр, механик эд ангийн хаалт хашлагыг нээлгүүлэх, түүнийг салгуулах зэрэг үйлдлийг зөвхөн тухайн тээврийн хэрэглийн жолоочоор гүйцэтгүүлнэ.
- Тээврийн хэрэгсэл дээр хяналт, шалгалтыг хийхдээ аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ, өргөх, буулгах механизм хүрэх,
- Чиргүүл дээр ачигдсан усан замын тээврийн хэрэгсэл дээр гарч зогсох, шаардлагагүй тохиолдолд доогуур нь орохгүй байх,
- Тээврийн хэрэгслийг тээвэрлэх, зөөвөрлөх, техник хэрэгслийн хөдөлгөөнд дэмжлэг үзүүлэхээр түлхэх, татах зэрэг үйлдэл хийхийг хориглоно.
- Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн ёроолын хэсгийг шалгах тохиолдолд чиргүүлийн тулаас, дугуйны ивээс хөдөлгөөнгүй бэхлэгдсэн эсэхийг зайлшгүй шалгана.
- Техникийн хяналтын үзлэгийг тусгайлсан талбайд явуулна.
- Тээврийн хэрэгслийг зориулалтын чиргүүлээр тээвэрлэхдээ сайтар бэхэлж, холбирч унах даруулахаас болгоомжилж, түүнээс тодорхой зай барина.
- Чиргүүлийн дор тулгуур байрлуулж, дугуйнд нь ивүүр хийсэн байна. Чиргүүлийн дугуйнд обуд, тоосго гэх мэтийн зориулалтын бус зүйлээр тулгуур хийхийг хориглоно.
- Өргөх механизмаар /домократ, таль гэх мэт/ усан замын тээврийн хэрэгслийг өргөсөн

үед доогуур нь орж үзлэг хийхийг хориглоно.

- Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс ялгарч буй утаан дахь хорт бодисыг хэмжихээс бусад тохиолдолд хөдөлгүүрийг унтрааж, сэнсний эргэлт бүрэн зогсоосны дараа техникийн үзлэг, оношлогоог хийнэ.
- Уг үзлэг, оношлогоо дуусахаас өмнө тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг асаах, хөдөлгөхийг хориглоно.
- Тээврийн хэрэгслийн хөдөлгүүр болон бусад цахилгаан тоног төхөөрөмжийн халсан эд ангид хүрч түлэгдэхээс сэргийлж ажиллана.
- Үзлэг оношлогоо хийхийн өмнө усан замын тээврийн хэрэгслийг зогсоолд бүрэн бэхэлсэн байхыг жолоочоос шаардана.
- Тээврийн хэрэгслийг чиргүүлээр чирж байх, болон хөдөлгөөн эхлүүлсэн үед шалгалт хийхийг хориглоно.
- Гол, мөрний усны түвшин нэмэгдэх, үер ус буусан, бороотой үед бага оврын усан замын тээврийн хэрэгслийг уснаас гаргаж, зогсоол, тохиромжтой газарт байрлуулсны дараа үзлэгийг явуулна.

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН КАТЕР БОЛОН АВРАХ ЗАВИНЫ ЖОЛООЧИЙН АЯЛАЛД ГАРАХЫН ӨМНӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА:

Хяналтын катер, аврах завины техникийн бүрэн бүтэн байдалд үзлэгийг хийж, бүрэн бус тээврийн хэрэгслийг жолоодохгүй байх, өдөр бүр ХАБЭА-н зааварчилгаатай тогтмол танилцаж бүртгэлийн дэвтэрт гарын үсгээ зурах бөгөөд ажлын хувцас, аврах хэрэгслээ бүрэн, зөв өмсөж ажил үүргээ гүйцэтгэнэ.

Усан замын тээврийн хэрэгсэл, түүний нэмэгдэл тоног, төхөөрөмжийн үечилсэн үзлэг, засвар үйлчилгээ хийхтэй холбогдсон стандарт, зааврын талаар ойлголттой байх шаардлагатай.

Урьдчилан сэргийлэх үйлчилгээний ач холбогдол, засвар, үйлчилгээг төлөвлөх, аюулгүй байдлыг хангах, засвар үйлчилгээ хийсэн тухай бүртгэл заавал хөтөлнө.

Усан замын тээврийн хэрэгсэлд зайлшгүй байх эд хэрэгслийг бүртгэж бүрэн бүтэн байдлыг шалгана. Үүнд:

- Аврах хантааз;
- Аврах цагираг;
- Дуут дохио (шүгэл);
- Гар чийдэн;
- Аврах олс (10-20 метрийн урттай);
- Хувин (завины ёроол цоорсон тохиолдолд усыг гадагшлуулах);
- Сэлүүр;
- Зангуу болон олс;
- Анхан шатны тусламж үзүүлэх эмийн сан;
- Засварын багаж хэрэгсэл орно.

Техникийн бүрэн бүтэн байдлыг шалгана. Үүнд:

- Усан замын тээврийн хэрэгслийн их биеийн ёроолд ус орсон эсэх, их биеийн гадна, дотор талд цооролт, цууралт үүссэн эсэх;
- Радио холбооны хэрэгсэл болон байршил тогтоох систем, (GPS) тоног

- төхөөрөмж хэвийн ажиллаж байгаа эсэх;
- Аккумуляторт богино холболт үүссэн, шингэн асгарч байгаа эсэхийг сайтар шалгана.

Хөдөлгүүрийн хэвийн ажиллагааг шалгана. Үүнд:

- Шатахуун болон шатах тослох материалын хэмжээ хэвийн түвшинд байгаа эсэх;
- Хөдөлгүүр асаахын өмнө хурдны хайрцагны удирдах хөшүүрэг нейтрал буюу N байрлалд шилжүүлсэн эсэхийг анхаарах;
- Завь, катерыг зогсоолд бүрэн байрлуулж бэхэлсний дараа хөдөлгүүрийг асааж, унтраах;
- Жолоодлого, залуурын ажиллагаа хэвийн эсэх;
- Хөдөлгүүрийн хөргөлтийн систем хэвийн ажиллаж байгаа эсэх;

Зорчигчдын аюулгүй байдлыг хангах үүднээс аюулгүй ажиллагааны зааварчилгааг зорчигчдод танилцуулна. Үүнд:

- Аврах хантааз хэрхэн өмсөх талаар зааварчилгааг зорчигчдод танилцуулан аврах хантаазыг зорчигчдын тоогоор өмсгөх;
- Зорчигчид усан замын тээврийн хэрэгслийн жолоочид шууд захирагдах үүрэгтэй;
- Зорчигчид зөвхөн усан замын тээврийн хэрэгслийн жолооч /ахмад/-ийн зөвшөөрлийн дагуу усан замын тээврийн хэрэгсэл /завь, катер, усан онгоц/-д хуваарилсан суудалд суух;
- Хяналтын катерыг савлуулах, усан замын тээврийн хэрэгслийн нэг талд бөөгнөрч хазайлт үүсгэхийг хориглох;
- Хийлдэг завь болон жижиг оврын завин дээр зогсоогоор зорчихыг хориглоно.

Хөдөлгөөн эхлүүлэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- Хөдөлгүүрийн аваарын унтраалгын хавхлагийг жолоочийн аврах хантаазнаас болон гаранд бэхлэнэ. (Энэ нь тээврийн хэрэгсэл жолоодох, удирдлага алдагдсан үед автоматаар хөдөлгүүрийг унтрааж тээврийн хэрэгслийг зогсоох найдвартай арга юм);
- Хөдөлгүүрийн ажиллагааг бүрэн шалгаж, ямар нэгэн доголдол ажиглагдаагүй нөхцөлд хөдөлгүүрийг асааж, хөдөлгөөнд оролцоно;
- Аврах завины хөдөлгүүр ажиллаж байх үед шаардлагагүй тохиолдолд радиаторын тагийг нээхгүй байх, хэрэв нээх тохиолдолд хөргүүрийн шингэн хэт халснаас халуун уураар тургиж, түлэгдэх аюултай тул болгоомжтой онгойлгох.
- Завь, катерыг аялалд бэлтгэн, аялалд гарахаас өмнө салхи, давалгаа, усны урсгалын чиг, хүчийг тодорхойлох ба зогсоолоос хөдлөхдөө усны гүнд тохируулан хөдөлгүүрийн сэнсийг усны ёроолд цохигдохоос сэргийлж, хөдөлгүүрийг өргөх, сэнсний эргэлтийг давхар хянана;
- Зогсоолоос хөдлөхдөө хөдөлгүүрийн сэнсний эргэлтийг хамгийн бага хурдаар эхлүүлэх ба зогсоол орчимд давалгаа үүсгэхгүй байхаар тооцно.
- Хөдөлгүүр ажиллаж байх үед сэнс, туузан дамжуулга зэрэгт орооцолдож осолд орж болзошгүй тул элдэв зүүлт, алчуур, хүзүүний ороолт, гинж, бугуйвч, зангиа зүүх, ажлын бус хувцас өмсөхийг хориглоно.
- Хяналтын катер, аврах завин дээр ажиллахдаа өндөр өсгийтэй болон хатуу ултай халтирах аюултай, мөн металл хадаастай болон тахтай гутал өмсөхийг хориглоно.

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖОЛООЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Усан замын тээврийн хэрэгсэл, хяналтын катер жолоодогч нь дараахь чадварыг бүрэн эзэмшсэн байна. Үүнд:

- Завь, катерыг аюулгүйгээр жолоодон, 180 градусаар огцом эргэлт хийх;
- Завь, катераар 360 градуст эргэлтийг аюулгүй гүйцэтгэх;
- Зогсоолд завины хажуугийн хэсгээр аюулгүй байрлуулах;
- Усанд унасан хүнд тусламж үзүүлэхүйц хэмжээнд дөхөж очих (тусламж үзүүлэхээр дөхөж очихдоо тухайн этгээдэд давалгаа үүсгэж, их хэмжээний ус цалгиулж, нөхцөл байдлыг хүндрүүлэхгүй байх);
- Эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх;
- Завь, катерын хурдыг тохируулах ба хөдөлгүүрийн хүчин чадлыг тооцоолох;
- Завь, катерыг зогсоолд байрлуулахаас гадна завь катерийн их бие, урд тал, хойд талаас зогсоол болон усны урсгалд тохируулан бэхлэх зэрэг анхан шатны мэдлэг чадваруудыг бүрэн эзэмшсэн байна;
- Далайд хэрэглэдэг уяа, зангилааг зангидах аргууд ба төрөл, зориулалтын талаарх мэдлэгтэй байх;
- Ослын үед усан замын тээврийн хэрэгсэл дээр болон усан дээр байгаа хүмүүст тусламж үзүүлэхээр дөхөн очиход анхаарах зүйл, тээвэрлэж буй зорчигч болон ачаанд ямар нэгэн эрсдэл учруулалгүйгээр аврах ажиллагаа зохион байгуулах арга, техник;
- Усан замын тээврийн хэрэгслийн /чиргүүл/ зангуу, аргамжаа /олс, уяаг ган тросс/-г хэрхэн бэхлэх, түүний зориулалт ба ашиглалт, хөвөгч тэмдэг, түүний хэрэглээ, утгыг таних.

ЦАХИЛГААНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЦАХИЛГААНААР АЖИЛЛАДАГ БАГАЖ, ТЕХНИК ХЭРЭГСЭЛТЭЙ АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Аливаа цахилгаан хэрэгсэлтэй харьцахын өмнө түүнийг ашиглах заавар, гарын авлагатай танилцах, зааврыг ойлгоогүй бол мэргэжлийн хүнээс туслалцаа авах, таамгаар ажиллахыг хориглоно.

Цахилгаанаар ажилладаг багаж, техник хэрэгсэлтэй ажиллахдаа дараах зааварчилгааг мөрдөж ажиллана. Үүнд:

- Цахилгаан төхөөрөмжийн ажиллагаа бүрэн зогссоны дараа үйлчилгээ хийх хэрэгтэй.
- Цахилгаан машин, багажийг цахилгаан сүлжээнд залгаатай нь болон хараа хяналтгүй орхиж болохгүй.
- Эд зүйлд болон хананд налуулан тавьсан шатан дээр цахилгаан багажаар ажиллахыг хориглоно
- Цахилгаан багажаар ажиллах үедээ хамгаалалтын нүдний шил заавал зүүнэ.
- Багажтай ажиллаж байх үед цахилгааны утсыг нугалах, мушгих, дээр нь хүнд зүйл тавихыг хатуу хориглоно.
- Цахилгаан багажийг нэг ажлын байрнаас нөгөөд зөөж шилжүүлэхдээ хүчдэлээс салгасан байх хэрэгтэй.
- Цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмжийг эх үүсвэрээс салгахдаа утаснаас зуурч татаж болохгүй. Утаснаас зуурч татсанаар, утас болон сэрээ, залгуурыг гэмтээх төдийгүй хүчдэлд цохиулах, гал түймэр гарах аюултай.

- Багажны тэжээлийн кабель нь шалбарсан хамгаалалтгүй ил гарсан байх ёсгүй.
- Ажил гүйцэтгэж дууссаны дараа ажлын байрыг эмхэлж цэгцлэн, багаж хэрэгслийг хайрцаг, саванд нь хийж зориулалтын тавиур дээр тавих.
- Цаг агаарын аюултай нөхцөлд задгай талбайд ажиллахыг хориглоно. /аянга, цахилгаан, бороо, цас, салхи, шуурга г.м/
- Тэсэрч дэлбэрэх аюултай бодистой ажлын байранд цахилгаанаар ажилладаг багаж ашиглахыг хориглоно.
- Ил задгай, чийглэг орчинд ашиглах залгуур, унтраалга, цахилгаан хэрэгслүүд нь ус, чийгний хамгаалалттай байх ёстой
- Унтраалгыг товчлуур дарж унтраасан хэдий ч цахилгаан хүчдэл хэвээр оршиж байдаг тул үзлэг шалгалт, цэвэрлэгээ, засвар үйлчилгээ гүйцэтгэхийн өмнө тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, уртасгагч залгуурыг цахилгааны эх үүсвэрээс бүрэн салгах шаардлагатай. Цахилгааны 2 фазад зэрэг хүрч болохгүй.
- Агаарын температур, чийг ихсэхэд хүний биеийн эсэргүүцэл багасч, организмын цахилгаан гүйдэл эсэргүүцэх чадвар буурдаг, агаарын даралт буурвал цахилгааны аюул ихэснэ гэдгийг анхаарч ажиллах хэрэгтэй.
- Ядарсан, өвчилсөн үед цахилгаан гүйдэлд мэдрэмтгий, өртөмтгий болдог. Ийм үед цахилгаан багаж хэрэгсэлтэй ажиллахаас зайлсхийх.
- Цахилгаан дамжуулах агаарын шугам тасарч газар унасныг мэдвэл 10 м-ээс дотогш ойртохгүй байх, мэргэжлийн байгууллага, ажилтанд мэдэгдэх.
- Тэсрэмтгий бодис агуулдаг байр, савны орчимд цахилгаан нум үүсгэх буюу цахилгаан утсыг хөвж тавихаас зайлсхийх.
- Шатамхай хий, хүчилтөрөгчөөр баялаг агаартай орчинд оч үсэрч болзошгүй цахилгаан хэрэгслийг ашиглахгүй байх.
- Аккумуляторын хүчдэлийн шонд гар, хуруугаа шууд хүргэхгүй байх, зөвхөн резинээр бүрсэн хамгаалалтын бээлийтэй ажил, үүргээ гүйцэтгэнэ.
- Аврах завины аккумуляторын дэргэд тамхи татах, ил гал гаргах, хүнсний зүйл хадгалах зэргийг хатуу хориглоно.
- Зөөврийн гэрлийн бариулыг дулаан чийгэнд тэсвэртэй материалаар хийх, гэрлийн гүйдэл дамжуулагч хэсгийг хамгаалттай байлгана.
- Хүчдэл бүхий төхөөрөмж, эд анги хэсгүүдэд хүн хүрэхээс найдвартай хамгаалахын тулд түүний хаалгыг үргэлж цоожтой байлгах. Ажлын байранд хаалт хийж, “ЗОГС, ӨНДӨР ХҮЧДЭЛД БҮҮ ХҮР, ӨНДӨР ХҮЧДЭЛИЙН ШОНД БҮҮ АВИР, ҮХЛИЙН АЮУЛТАЙ, БҮҮ ЗАЛГА, ШУГАМАНД АЖИЛ ГҮЙЦЭТГЭЖ БАЙНА, БҮҮ ОНГОЙЛГО” зэрэг тохирох анхааруулах санамжийг байрлуулах,
- Ажлын байранд хүчдэл байгаа эсэхийг гараар хүрч шалгахыг хориглоно.
- Трансформаторт гэмтэл, хэт халалт илрүүлбэл шугамд түр салгалтыг заавал цахилгаанчнаар гүйцэтгүүлнэ.

АВРАХ ЗАВЬ, ХЯНАЛТЫН КАТЕРИЙГ УСНААС ГАРГАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Завь, катерийг уснаас гаргахдаа аюулгүй ажиллагааны дараах зааварчилгааг баримтлан ажиллана. Үүнд:

- Чиргүүлийн дугуйны хий бүрэн эсэх,
- Завинд тохирох даац бүхий чиргүүлийг сонгон хэрэглэх,
- Бэхэлгээний уяа бүрэн бүтэн эсэх,
- Чиргүүлийн эд анги ачааллыг даахуйц, эвдэрч гэмтээгүй эсэх,

- Завь, чиргүүл дээр хөдөлгөөнгүй, найдвартай ачигдаж, бэхлэгдсэн эсэх,
- Завины хүндийн төвийн тэнцвэрийг олж, аюулгүй байдлыг хангах,
- Хэрэв автомашинаар чирэх тохиолдолд завь болон авто машины хооронд хангалттай зай байгаа эсэхийг шалгах,
- Чиргүүлийг чирэх автомашиндаа зөв бэхэлж, бүх холболтууд хоорондоо холбогдсон, аюулгүйн гинж, олс, уяа найдвартай байгаа эсэх,
- Завийг өвлийн зогсоолд байршуулах үед цахилгаан тросс татах төхөөрөмж бүрэн ажиллаж байгаа эсэхийг урьдчилан сайтар шалгах,
- Зогсоолд завийг оруулахдаа хөдөлмөрийн аюулгүй байдлаа сайтар хангаж гар, хөлөө хавчуулахаас болгоомжлох,
- Урт хормойтой, сул ханцуйтай цамц, нэвсгэр хувцас өмсөхгүй байх, тросс утсанд орооцолдохоос болгоомжлох,
- Аврах завийг усанд оруулах, уснаас гаргахдаа чирэх, татах /либотка/ төхөөрөмжийг ажиллуулах туршлагатай 2-оос доошгүй хүнтэй гүйцэтгэж байхаас гадна ачаа холбирах, унах аюултайг тооцож, аюулгүй ажиллагааг бүрэн хангана.
- Хяналтын катер, аврах завийг зогсоолд байрлуулсны дараа чиргүүлийн арал, тэнхлэг дор тулгуур, бэхэлгээ хийх, дугуйн урд, хойд талд зориулалтын ивээс хийнэ.

ХЯНАЛТЫН КАТЕР БОЛОН АВРАХ ЗАВИНД ЗАСВАР ҮЙЧИЛГЭЭ ХИЙХ, ӨВЛИЙН БИТҮҮ ЗОГСООЛ, ГАРАЖ /ОНОШИЛГООНЫ БАЙР/-Т АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Хяналтын катер болон аврах завинд засвар, үйчилгээ, оношилгоо хийх үед аюулгүй ажиллагааг ханган техник ашиглалтын дүрмийг мөрдөж ажиллана. Үүнд:

- Уг ажлын байранд амархан гал авалцах шингэн болон агаарт дэгдэмхий бодис хадгалахыг хориглоно.
- Засвар хийх үедээ ХАБЭА-н зааварчилгааг чанд баримталж ажиллах ба бүрэн ажиллагаатай багаж, хэрэгслээр засвар үйлчилгээ хийх,
- Урсгал засвар, техникийн үйлчилгээний бүртгэлийг завь, катер тус бүр дээр хөтлөх.
- Засвар, үйлчилгээ эхлэхийн өмнөх ажлын байрны эмх цэгц, цахилгаан багаж, хэрэгслийн ажиллагааг шалгаж, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан орчинд гүйцэтгэнэ.
- Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн хэрэглэж, аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцаж, дэвтэрт гарын үсэг зурсан байна.
- Талбай нь тэгш бус, зөөлөн хөрстэй газарт техник байрлуулах, цаг агаарын таагүй нөхцөлд засвар, үйлчилгээний ажил гүйцэтгэхийг хориглоно.
- Засвар, үйлчилгээ, оношилгоо хийх ажлын байрны гэрэлтүүлэг хангалттай байх ба нүд гялбуулахгүй байхад анхаарна.
- Завины эд ангиудыг засварлах, турших үед санамсаргүйгээр унахаас болгоомжлох,
- Тээврийн хэрэгслийн хүнд /15 кг-аас дээш жинтэй/ агрегат, эд ангийг өргөх, салгах, угсрах, тээвэрлэхдээ зориулалтын өргөх механизмыг ашиглана.
- Хөдөлгүүрт засвар, үйлчилгээ хийхдээ зөөврийн өргөгч цамхаг ашиглах ба засварыг зориулалтын ажлын байранд гүйцэтгэнэ.
- Ачаа өргөх механизмын татлагад /тросс/ өлгөгдсөн техник хэрэгслийн дор байх, ажиллахыг хориглоно.
- Хортой хийнд хордохоос сэргийлж, аврах завины хөдөлгүүрийг 5 минутаас илүү хугацаанд агааржуулалтгүй байранд удаан ажиллуулахыг хориглоно.
- Хяналтын катер болон аврах завины хөдөлгүүр ажиллаж байхад техникийн үйлчилгээний бүх төрлийн ажлыг гүйцэтгэхийг хориглоно. “ХӨДӨЛГҮҮР АСААЖ

БОЛОХГҮЙ. ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙЖ БАЙНА” гэсэн санамжийг удирдлагын хэсэгт байрлуулах;

- Засварын ажлын үед хариуцсан мэргэжилтний зөвшөөрөлгүйгээр тоног төхөөрөмж, тохируулга шалгалт хийж, хүчдэл өгч хэрхэвч болохгүй.

САХИУЛ, МАНААЧИЙН АЖИЛ ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

- Хяналтын постын гадна, дотор талын (барилга, хашаа, байшин, гараж зогсоол, эд хөрөнгө) бүрэн бүтэн байдлыг хариуцаж, аюулгүй байдлыг ханган ажиллана.
- Сахиулын өрөөнд будаг, бензин, солярка зэрэг химийн хорт бодис хадгалахыг хориглоно.
- Өрөөг дулаацуулах зорилгоор ил задгай тень, плитка залгах, залгаатай орхиж гарах, плитка залгаж тамхи асаах зэргийг хориглоно.
- Гэрэлтүүлэг чийдэн шатсан ба гэмтсэн үед даруй удирдлагад мэдэгдэж солиулах, гэмтлийг засуулах арга хэмжээ авна.
- Автомашинуудыг эмх замбараатай, гарцыг чөлөөтэй байхаар зогсоолд тавиулна.
- Цахилгаан залгуурыг дур мэдэн залгах, салгахыг хатуу хориглоно.
- Удирдлагын зөвшөөрөлгүй байгууллагын хашаа, гараж, талбайд гадны машин тавиулахыг хориглоно.
- Сахиулын өрөөнд гадны хүн оруулах, байлгахыг хориглоно.
- Хяналтын байранд томилолтоор ажиллаж байсан мэргэжилтнүүдийг буцах үед байрыг хүлээн авч бүх өрөө, тасалгааны гэрэлтүүлэг, цоож, цонх, хаалгануудын байдалд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг цаг алдалгүй шуурхай авна.
- Хяналтын байрны орчин тойрон, зам талбай, довжоо, хашааны дотор, гадна байрлалд зохих цэвэрлэгээг хийж хэвшинэ.
- Хариуцсан объектоо тодорхой хугацаанд эргэн тойрч, гарч болзошгүй гал, усны болон гэнэтийн аюул, хулгай дээрмээс сэргийлэх зорилгоор үзлэг, шалгалтыг тогтмол хийж, илэрсэн зөрчлийн талаарх шуурхай мэдээллийг удирдлагуудад болон зохих албан байгууллага (цагдаа, гал команд гэх мэт)-д зохих журмын дагуу мэдэгдэнэ.
- Хариуцсан объектуудын цоож, лац ломбыг нарийн шалгаж, илэрсэн зөрчлийг тухайн ажилтнаар арилгуулж хүлээн авсан тухай тэмдэглэл хөтлөн гарын үсгээр баталгаажуулна.
- Завины битүү зогсоол, хяналтын постын барилга байгууламжийн өрөө тасалгааг гал, усны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай үед онгойлгон үзэж магадлах, цаг алдахгүй арга хэмжээ авах үүрэгтэй.
- Ажилтан, албан хаагчид болон иргэдээс биеийн байцаалт (ажлын газрын үнэмлэх, иргэний үнэмлэх)-ыг нь шаардах ба ажлын бус цагаар онцын шаардлагагүй болон согтууруулах ундаа хэрэглэсэн хүнийг хяналтын постын байранд нэвтрүүлэхийг хориглоно.
- Ажлын байранд архи, согтууруулах ундаа хэрэглэж буй тохиолдол илэрсэн үед удирдлагад шуурхай мэдэгдэнэ. Сэжиг бүхий иргэдийн талаар цагдаагийн байгууллагад яаралтай мэдэгдэх, онцгой шаардлагатай албан тушаалтан, ажилтнуудын утасны жагсаалтыг бэлэн байдалд байлгаж, хэрэглэж хэвшинэ.
- Цахилгааны утасны гадна бүрхүүл гэмтсэн шалбарсан үед, залгуурыг 220 вольтын хүчдэлд залгахыг хориглоно.

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАН АЖИЛЛАХ ЗААВАРЧИЛГАА

Техникийн засвар, үйлчилгээ хийдэг байранд галын аюулгүй ажиллагааны дүрмийг хатуу мөрдөнө.Үүнд:

- Шатах тослох материал арчсан алчуур, даавууг ил задгай хаяхгүй, цахилгаан, ил гал, нарны шууд тусгалаас хол байлгах,
- Хаалга, гал унтраах хэрэгсэл байгаа газрын орчимд хог, хаягдал овоолох, тээврийн хэрэгслийг байрлуулах, амархан гал авалцах материалыг ил саванд хадгалахыг хориглоно.
- Хэрэв зөөврийн цахилгаан гэрэлтүүлэг хэрэглэх шаардлагатай бол гэрэлтүүлэгт хамгаалалтын тор байгаа эсэх болон залгуур тусгаарлах резинэн гуурс бүрэн, бүтэн эсэхийг шалгана.
- Бензиний сав, бензиний хоолойд бензиний үлдэгдэл байгаа эсэхийг шалгах.
- Агрегатаас тос, усыг зөвхөн тусгай зориулалтын газарт юүлнэ. Шалан дээр гоожсон тос буюу шингэнийг нэн даруй хуурай элс, үртэс цацан, тусгай газарт цуглуулна.
- Гагнуурын ажил гүйцэтгэхдээ бензин болон бензин зөөвөрлөхөд ашиглаж байсан савыг ойрхон байлгахыг хориглоно.
- Гал түймэр гарсан тохиолдолд гал унтраах байгууллагад яаралтай мэдэгдэн, унтраах арга хэмжээ авна.
- Гал түймэр гарсан тохиолдолд хүмүүсийг аюулгүй газарт гаргах арга хэмжээ авах.
- Гал түймэр гарсан тохиолдолд цахилгаан хэрэгслийг цахилгааны тэжээлээс салгах.

УРТАСГАГЧ ЗАЛГУУРТАЙ АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

- Уртасгагч залгуурыг цахилгаанаас салгахдаа кабелиас нь татаж болохгүй.
- Уртасгагч кабелиар цахилгааны байнгын буюу суурин утсыг орлуулж болохгүй. /Байшингийн хана туурганд хадаж тогтоож болохгүй./
- Цахилгааны залгуурыг уртасгахын тулд зориулалтын бүтэн бүтэн ажиллагаатай уртасгагч ашиглах бөгөөд зориулалтын бус кабель холбохыг хориглоно. Залгасан уртасгагч болон хэт урт уртасгагч нь хүчдэлийн хэмжээг бууруулдаг бөгөөд багаж, төхөөрөмжийг гэмтээж болох аюултайг анхаарах.
- Уян кабель болон цахилгааны утсыг шалбарах, гэмтэхээс хамгаалах, доторх утаснуудыг тусгаарладаг бүрээс нь зүсэгдсэн, урагдсан, цуурсан эсэхийг байнга шалгаж байх. Ил монтаж хийсэн цахилгааны утас нь ороолцолдох, бүдэрч унах аюултай тул цахилгааны утсыг үүдний ерөө, хана, цонх, тааз, шалан дээгүүр хөндлөн татаж болохгүй.
- Мэргэжлийн болон зөвшөөрөлтэй хүн уртасгагч утсыг засах, кабелийг солино.

АЧААГ ГАРААР ӨРГӨХ, ЗӨӨХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

- Баглаа боодолтой болон бусад ширхэгийн ачааг зөөвөрлөхдөө гараа шархлуулахгүйн тулд бүгдийг нь урьдчилан сайтар шалгаж үзэх хэрэгтэй, / төмөр баглааны үзүүр, хадаасанд гараа ураг, зүсэх эрсдэлтэйг анхаарах./ Хайрцгийг буюу боодлыг хураасан газраас авахдаа хажууд нь байгаа ачаа унахгүй, тогтвортой байдалд байгаа эсэхийг

шалгах хэрэгтэй. Ачааг зөвхөн хураалтын дээд талаас авбал зохино. Ачааны хүнд, хөнгөнийг сайн тохируулах. Хэт хүнд, овор ихтэй ачаа өргөхгүй байх.

- Ачаандаа үнэлгээ хийх-Өргөж явах хооронд ачааны зарим хэсэг хөдөлж болох эсэх /бөөрөнхий зүйлс, лонх, хуйлсан зүйл гэх мэт/.
- Хөлөө зөв тавих. /нэг хөлөө ачааны ард, нөгөө хөлөө явах гэж байгаа зүг рүүгээ харуулж ачааныхаа хажууд тавь./
- Ачаанд хүрэх гэж бүсэлхийгээрээ бүү тонгой. Өвдгөө нугал. /дараа нь доошоо тонгойж ачаандаа хүр./
- Ачаагаа эсрэг хоёр талаас нь чанга барь.
- Ачааг бүсэлхийгээрээ тонгойсон үедээ бүү өргө. Ачаа өргөж байхдаа огцом хөдөлж, эргэж болохгүй.
- Яаж өргөхөө төлөвлө.
- Замд тээглэх зүйлсийг холдуул.
- Өөрөө өргөж чадахааргүй бол бусдаас тусламж ав.
- Хүнд, овор хэмжээ ихтэй барааг зөөхдөө өргөх механизм ашигла.
- Баллон шил савыг зөөвөрлөхдөө тусгай тавиур дээр тавьж зөөвөрлөх ба ийм ачааг зөөх, өндөрт гаргахдаа бие дээрээ зөөвөрлөхийг хориглоно.
- Бургидаг ачааг зөвхөн тоос үл нэвтрэх нүдний шил ба амьсгалуур хэрэглэсэн нөхцөлд гараар ачиж буулгаж болно.
- Өдөр бүр ажлын тусгай хувцасны тоосыг гөвнө. Амьсгалуурын шүүлтүүрийг бохирдвол солих ёстой.
- Хлорт шохойг ачиж буулгахдаа шүүлтүүртэй буюу амьсгалууртай хорт хийн багийг заавал өмсөнө
- +40° С ба түүнээс дээш халуун байгаа үед цементийг гараар ачиж болохгүй.
- Хүний гараар өргөх ачааны дээд хэмжээ нь стандартад заасны дагуу эмэгтэй хүн - 20 кг, эрэгтэй хүн — 36 кг байна.

ЖОЛООЧИД ӨГӨГДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

- Тээврийн хэрэгслийн жолооч нар нь замын хөдөлгөөнд оролцох болон автомашинд засвар үйлчилгээ хийх үедээ "Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм"-ийг дагаж мөрдөх, гарч болох аюул, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү ХАБЭА зааварчилгааг дагаж мөрдөнө.
- Жолооч нар нь ажилд гарахын өмнө болон албан томилолтоор явахдаа холбогдох албан тушаалтнаас ХАБЭА зааварчилгааг авч, танилцсан талаар гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.
- Жолооч нь тээврийн хэрэгслийн аюулгүй, бүрэн бүтэн байдлыг хариуцаж, хөдөлгөөнд оролцохдоо тээврийн хэрэгсэлд урсгал болон их засвар хийх тохиолдолд дараах зааврыг дагаж мөрдөн ажиллах шаардлагатай.
- Хувийн болон техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна.
- Зөвшөөрөлгүйгээр дур мэдэн хувийн зорилгоор албаны тээврийн хэрэгслийг ашиглахгүй байх, ашигласан тохиолдолд гарсан үр дагавар, хариуцлагыг жолооч өөрөө хариуцах бөгөөд албан байгууллага ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.
- Согтуугаар болон тээврийн хэрэгсэл жолоодох чадамжгүй үед автомашин жолоодохыг хатуу хориглоно.
- Жолоо шилжүүлэх, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй хүнээр жолоо бариулахыг хориглоно. Жолоо шилжүүлснээс үүсэх үр дагавар, хариуцлагыг тухайн тээврийн хэрэгслийн жолооч өөрөө хариуцна.

- Замын хөдөлгөөнд оролцохдоо гар утас болон бусад анхаарал сарниулах зүйлсийг ашиглахгүй байна.
- Тээврийн хэрэгслийн хурдыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэх, шалтгаангүйгээр хэт удаан явах, огцом зогсох, хөдөлгөөн саатуулах, тээврийн хэрэгсэлд дуут дохио болон гэрлэн дохио дур мэдэн тавихыг хориглоно.
- Тээврийн хэрэгслийн суудлын тоогоор зорчигчдыг суулгах, хүн хэтрүүлж суулгахгүй байна.
- Зорчигчийг тээврийн хэрэгсэлд бууж, суух үед зөвшөөрөгдсөн зогсоолд зогсож, гүйцэд бууж, суусны дараа хөдөлнө.
- Шатахуун түгээх газар болон шатах, тослох материалын ойр орчимд ил гал гаргах, тамхи татахыг бүрэн хориглоно.
- Өвөл, зуны улиралд зориулалтын дугуйг ашиглах ба хол замд гарахаар бол хүрз, тросс, паяльник зэрэг зайлшгүй шаардлагатай зүйлсийг авч явна.
- Ажлын байранд болон тээврийн хэрэгсэлд гал унтраах багаж хэрэгслийг байнга байлгаж, зориулалтын бус зүйлд ашиглахгүй байна.
- Шаардлагатай тохиолдолд хэрэглэх дараах эд зүйлсийг бэлэн байлгах. Үүнд:
- Галын хор, ослын гурвалжин болон засвар хийхэд шаардлагатай багаж, хэрэгсэл
- Ажлын бээлий, нүдний шил, амны хаалт, нойтон салфетка, эмийн сан гэх мэт.
- Автомашины цэвэрлэгээ, үйлчилгээг тогтмол хийж, шороо, тоос, ус, цас, мөс, тосыг байнга арчиж цэвэрлэх, эд зүйлсийг цэвэр, эмх цэгцтэй байлгана.
- Ус, тос, маслыг байнга шалгах, нэмэх, шинээр сольж байх шаардлагатай.
- Автомашины эрэг, боолтуудыг тогтоосон хугацаанд шалгаж, чангалж байна.
- Автомашиныг жил бүр оношилгоонд оруулж, түүний дагуу шаардлагатай засвар үйлчилгээг хийж байна.
- Засвар, үйлчилгээг хийхдээ автомашины мотор хөдөлгүүрийг бүрэн зогсоож, унтраасны дараа засварын ажлыг эхлүүлнэ.
- Засварын ажлын явцад өргөж, буулгах механизмуудын даацыг хэтрүүлэхгүй байна.
- Зөөврийн цахилгаан гэрэл ашиглахдаа 6 вольтоос илүү хүчдэлтэйг хэрэглэхгүй байх, чийгтэй нойтон орчинд 12 вольтоос илүү хүчдэлтэйг үл хэрэглэнэ.
- Цахилгаан багажаар ажиллах үед хамгаалалтын бээлийг заавал өмсөж, төмөр дээр зогсож, цахилгаан багажаар ажиллах бол хамгаалалтын резинэн дэвсгэр хэрэглэнэ.